



ХЭНТИЙ АЙМАГ
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 17 өдөр

Дугаар 4/177

Өмнөдэлгэр сум

Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх
вакцинжуулалтын ажлыг зохион байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8, 9.9 дэх заалт, аймгийн Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн А/472 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 2024 онд шинээр гарсан сумын хэмжээний бүх тугал, хурга, ишгийг зааврын дагуу дархлаажуулах ажлыг төлөвлөгөөт хугацаанд зохион байгуулсугай.
2. Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдах төлийн тоог хавсралтаар баталсугай.
3. Дархлаажуулалтын ажилд онцгой ач холбогдол өгч, малчдад зар хүргэх, тарилгын хашаа хоолойг бэлтгэх ажлыг чанартай зохион байгуулахыг багийн Засаг дарга нарт даалгасугай.
4. Тарилгын явц, гүйцэтгэлд хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангаж, тарилгын дүн болон санхүүгийн баримт материалыг бүрдүүлэн аймгийн Мал эмнэлгийн газарт хүргүүлэхийг Мал эмнэлгийн тасагт үүрэг болгосугай.



Б.ЭРДЭНЭБААТАР


 сумын Засаг даргын 2024 оны
 09 дугаар сарын 17-ны өдрийн
 А/177 дугаар захирамжийн хавсралт

Өмнөдэлгэр сумын 2024 онд бруцеллээс өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтанд хамрагдах төл мал, вакцины хуваарь

№	МЭҮНэгж	Хамрагдвал зохих төл малын тоо				Бүгд	Шаардагдах вакцин /тун/		шт19 /шир/	Rev-1 /шир/	Шингэлэгч /литр/		
		Тугал	Хурга	Ишиг	бог		Штам-19	Rev-1			мл	хайрцаг	шил
1	Юмт гэгээ	5440	36868	29145	66013	71453	5440	66013	68	165	76893	12	25
2	Өвөр зотлог	960	6003	4422	10425	11385	960	10425	12	26	12345	2	2
3	Хэйлти анимал стронг	1840	13600	8398	21998	23838	1840	21998	23	55	25678	4	9
4	Хичээнгүй экспресс	1600	16400	11164	27564	29164	1600	27564	20	69	30764	5	3
5	Мэргэн жонон	2000	16800	9200	26000	28000	2000	26000	25	65	30000	5	
	Дүн	11840	89671	62329	152000	163840	11840	152000	148	380	175680	28	39